



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



# Байгаль орчны аудитын хэрэгжилтийн өнөөгийн байдал

2017-12-01

Улаанбаатар хот



## Байгаль орчны аудитын тухай ойлголт

- Аливаа аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчны талаарх /эрх зүй, бодлого/ хэрэгжилтийг тоон үзүүлэлтээр дүгнэх арга хэрэгсэл
- Байгаль орчны аудитын үндсэн 3 төрөл байдаг. Байгаль орчны хуулийн хэрэгжилтийн (environmental compliance audits), байгаль орчны менежментийн гүйцэтгэлийн (verify whether an organization meets its stated objectives), үйл ажиллагааны (water, electricity etc)
- Ач холбогдол тухайн аудитын зорилгоос хамаарч янз бүр хуулиар хүлээсэн үүргээ сайн ойлгох, байгаль орчны бодлогыг хэрэгжүүлж байгааг нотлох, эрсдлийг урьдчилан тооцох, эдийн засгийн үр ашигтай байх гэх мэт



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



## Байгаль орчны аудитын үүсэл, хөгжил

- 1970-аад оны сүүл, 1980-аад оны эхээр АНУ-ын хувийн хэвшлийн үйлдвэрүүд анх ашиглаж эхэлсэн.
- Европын холбоо, Австрали зэрэг улсуудад хөгжсөн.
- Австрали, АНУ, Европын холбоо зэрэг хөгжилтэй орнууд Уганда зэрэг хөгжиж буй орнууд үндэсний хууль тогтоомжоо баталж гаргасан.

*/mandatory vs voluntary/*



## Байгаль орчны аудит Монгол улсад

- БОА-ын талаар “Байгаль орчныг хамгаалах тухай” хуульд бие даасан зүйл оруулж 2012 оны 5 дугаар сард УИХ-аар батлуулсан.
- “Байгаль орчны аудит” гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг хэлнэ гэж заасан байдаг.



## Байгаль орчны аудитын эрх зүйн орчин


- Байгаль орчныг хамгаалах тухай хууль /2012он/
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 1 дугаар хавсралт

### **“Байгаль орчны аудит хийх эрх олгох журам”**

- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

### **“Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал”**

# Монгол улсад Байгаль орчны аудитын түүхэн хөгжил



# Аудитын ач холбогдол

01 БО хамгаалах

02 Эрх зүй


Улсын хууль дүрэм, ОУ-д нэгдэн орсон гэрээ конвенцийг даган мөрдөж

03 Асуудлаас урьдчилан сэргийлэх

Одоогийн болон ирээдүйд учирч болох асуудлуудыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх

04 БО сайн гүйцэтгэл

Компаниуд байгаль орчны сайн гүйцэтгэлд суурилж ажиллах



05 Зардал хэмнэх

Зардал хэмнэх боломжуудыг олж илрүүлэх, жишээ нь хог хаягдлын үр ашигтай менежмент

06 Мэдээлэл

Өөр бусад ААН үйлдвэрүүд болон өөрийн охин компаниудтай мэдээлэл солилцох, харьцуулалт хийх боломжыг олгоно

07 Амлалт

Бизнес нь байгаль орчин хамгаалах талаар төр, олон нийт, ажилчид болон бусад оролцогч нарт амалсан амлалтаа бичлүүлэх



## Төрийн захиргаанын төв байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагаас хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн
- Боловсон хүчнийг бэлтгэсэн
- Аудитын мэргэжлийн байгуулагын эрх олгосон
- Аудитын тайланг аймаг, нийслэлийн Байгаль орчны газраас авч нэгтгэн сан бүрдүүлж байна.
- Аудитыг Мэргэжлийн хяналтын газрын хяналтын хуудсанд оруулав.







## Аудитын боловсон хүчний байдал

- Байгаль орчны аудитын үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.
- Өнөөгийн байдлаар нийт 29 аж ахуй нэгж байгаль орчны аудитын эрхтэй.
- 164 аудитор 4 удаагийн сургалтаар бэлтгэгдсэн байна.

## БОА-ын хэрэгжилтийн байдал



## БОА-ын хэрэгжилт аймгуудын байдлаар





## БОА хийлгэсэн аж ахуй нэгжүүд

- Сүхбаатар аймагт Сайн хөвөөр хүрэн нүүрсний уурхай-Бүтээлч энх хөдөлмөр ХХК
- Оюутолгой ХХК –Эко-Акюрэси ХХК
- Дорноговь Алаг толгод нүүрсний уурхай –ЭТАБ ХХК
- Баянхонгор алтны шороон орд Рео – Цэхи Консалтинг ХХК
- Булган Өгөөжбаян ХХК -Цэхи Консалтинг ХХК
- Дорноговь Доншен газрын тос “монгол” ХХК -Цэхи Консалтинг ХХК
- Өмнөговь Цант-Уул нүүрсний орд –Эко Вооч ХХК
- Сэлэнгэ Бороо Гоулд Алтны шороон орд-Эко Вооч ХХК
- Завхан Баян айраг алтны уурхай -Эко Вооч ХХК
- Өмнөговь Саусгоби Сэндс - Эко Вооч ХХК
- Өмнөговь Оюутолгой- БОАД ХХК
- Өмнөговь Эрдэнэс таван толгой-БОАД ХХК
- Баянхонгор Оргил Моун ХХК -БОАД ХХК
- Баянхонгор ЖИ ЭНД ЮУ ГОЛД-БОАД
- Булган Баруун Захцагийн алтны шороон орд-ГБНБ ХХК
- Булган Цоохор морьт алтны шороон орд-Цэхи Консалтинг ХХК



## БОА-ын зөвлөмжийн чиглэлийн тойм

- Агаарын чанар
- Химийн хорт болон аюултай бодисын менежмент
- Нөхөн сэргээлт
- Усны чанар
- Хог хаягдлын менежмент



## Нийтлэг зөвлөмж

1. Дотоод хяналт шалгалтыг тогтмолжуулж, түүний мөрөөр зохих ажлын үр дүнг сайжруулах
2. Хөдөлмөр аюулгүй ажиллагааг хангахад тавих хяналт сайжруулах
3. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа усны найрлагад тусгай шинжилгээ жил бүр хийж байх
4. Нөхөн сэргээлт хийсэн тайлбайд биологийн нөхөн сэргээлт дахин хийх
5. Шимт өнгөн хөрсийг хуулан, овоолго хийж хадгалах, зохих хугацааны дараагаар техникийн нөхөн сэргээлт хийгдсэн үед биологийн нөхөн сэргээлтэд ашигладаг технологийг өөрчлөх
6. Химийн бодисын тавиур нь гулсаж унахаас хамгаалсан хаалт, саадтай байх. Эрсдлийн үнэлгээний тэмдэглэгээ тавих.
7. Хууль, тогтоомжид заасан дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллагад тайлан, мэдээг хугацаанд нь албан ёсоор хүргүүлдэг болох

## Оролцогч талуудын санал

- СЕСМИМ төсөлтэй хамтран аудитын эрхтэй аж ахуй нэгжүүдийн төлөөлөл, компани, төрийн байгууллагууд оролцсон хэлэлцүүлэг 2 хэлэлцүүлэг зохион байгуулсан. Байгаль орчны аудитын тулгамдаж буй асуудлын талаар.
- Хууль эрх зүйн - БОА-ын урамшуулах механизм, хариуцлагын механизм сайжруулах
- БОА-н гүйцэтгэлийг шалгах, сайжруулах механизм бий болгох / БО-ны Аудиторын зэрэглэл тогтоох/
- Аудиторуудын чадавхи сайжруулах хэрэгтэй гэсэн санал гарсан.



## Тулгамдаж буй асуудлууд

- Аудит хийлгэсэн тоо баримтаас үзэхэд аж ахуйн нэгж, байгууллага хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахгүй байна.
- Аудитын мэргэжлийн боловсон хүчний чадавхи сул
- Байгаль орчны албад аудитын зөвлөмжийг хэрэгжилтийг хангуулж ажиллахад тавих анхаарал сул
- Орон нутагт аж ахуй нэгжүүд аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн дүнг заагдсан хугацаанд өгч хэвших хэрэгтэй.





## Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Аудитын нэгдсэн арга зүй, хяналтын хуудас боловсруулж мөрдүүлэх
- Аудитын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах
- Аудитын ач холбогдлын талаар аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан сургалт тогтмол зохион байгуулах
- Хууль эрх, зүйн орчныг боловсронгуй болгох
- Гадаад улс орны туршлагыг судлах, нэвтрүүлэх



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



**Анхаарал тавьсанд баярлалаа!**